



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 1 дүгээр
сарын 3-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар
хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай

1. Иргэн Р.Батдэлгэр, “Цаглашгүй эрдэм” ХХК, “Зуун хаан” ХХК нарын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1, 28.2-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг нотлох баримттай танилцаж тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах болон хуульд заасан бусад эрхийг олгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай” Ерөнхий сайдын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 80 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ